



БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ
НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 05 сарын 10 өдөр

Дугаар 5/68


Өлгий

Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг
шинэчлэн батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь заалт, эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1 дэх заалт, нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа MNS5095:2017 стандартын 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нэгдсэн эмнэлгийн хэмжээнд хэрэгжүүлэх "Хүний нөөцийн (2023-2025) хөгжлийн хөтөлбөр"-ийн агуулгыг нэгдүгээр, төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.
2. Шинэчилэн баталсан хөтөлбөрийг нийт ажилт, албан хаагчдад танилцуулж, хэрэгжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулж ажиллахыг хүний нөөцийн албанд, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд удирдлага, арга зүйгээр ханган, хяналт тавьж ажиллахыг эмнэлгийн тусламж үйчилгээ эрхэлсэн дарга (А.Данабек)-д тус тус үүрэг болгосугай.
3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсөв, зардлыг тооцож, жил бүрийн төсөвт тусган ажиллахыг ерөнхий ня-бо (Б.Ууганбаатар)-д зөвшөөрсүгэй.


ДАРГА



Х.МАНЧУК

95

2023 оны 05-р сарын 10-ны өдрийн
5/08 тоот тушаалын нэгдүгээр хавсралт



АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар

Удиртгал

Нэг. Нийтлэг үндэслэл

Хоёр. Зорилго, зорилт

Гурав. Хамрах хүрээ, хугацаа

Дөрөв. Хэрэгжүүлэх зарчим

Тав. Санхүүжилт

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

Долоо. Хөтөлбөрийн хяналт, шинжилгээ үнэлгээ, шалгуур үзүүлэлт

Найм. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө

Нэг. Нийтлэг үндэслэл

Хүний нөөцийн тулгамдсан асуудал, хүний нөөцийн хангалтад онцгой анхаарч, тогтвор суурьшилтай ажиллуулах, ур чадварыг хөгжүүлэх болон ажиллах нөхцөлийг сайжруулах Хүнийг хөгжүүлэх тусам жилээс жилд үнэ цэнэ нь өсөж, боловсорч хөгжихийн хирээр сэтгэж, сэтгэхийнхээ хирээр бүтээдэг онцлогтойгоор бусад нөөцүүдээс давуу талтай байдаг.

ЭМСалбарын өөрчлөлт, шинэчлэл, нэгдсэн эмнэлгийн зорилт, чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд мэдлэг чадвартай хүний нөөцөөр бэхжүүлэн, иргэдэд ойр, уян хатан, үр дүнд чиглэсэн чанартай эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх хариуцлагын шинэ тогтолцоог бий болгож урьд урьдаас улам илүү их мэдлэг чадвар бүхий хүний нөөцийг хөгжүүлэх нь уг хөтөлбөрийг боловсруулах үндэслэл болж байна.

Хөтөлбөрийн эрх зүйн үндэс: Монгол Улсын Үндсэн хуулийн 46 дугаар зүйлийн 46.3-т "Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгааг хуулиар тогтооно", эрүүл мэндийн тухай хуулийн 20.2.7-д "Эмнэлгийн мэргэжилтэнд мэдлэг мэргэжлээ дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, ажилтны нийгмийн баталгааг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх" Хөдөлмөрийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйл "төрийн албан хаагчид олгох цалин хөлс", 59 дүгээр "Төрийн албан хаагчид олгох нөхөх төлбөр", 60 дугаар "төрийн албан хаагчид олгох тусламж", 61 дүгээр зүйл Төрийн албан хаагчийн нийтлэг баталгаа, зэрэг бусад холбогдох хууль тогтоомж, эрүүл мэндийн хөгжлийн бодлогод эрүүл мэндийн хүний нөөцийн хөгжлийн зорилт тусгагдаж, эмнэлэгийн мэргэжилтэн бэлтгэх сургалт, тэдний цалин хөлс, урамшуулалын тогтолцоог боловсронгуй болгох, үйлчлүүлэгчид төвтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хөгжүүлэх, хүний нөөцийн хувиарлалтыг зохистой болгох асуудлууд тусгагдсан нь хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр боловсруулах эрх зүйн үндэс болж байна.

Хоёр: Хөтөлбөрийн зорилго:

2.1 Байгууллагын хараа, эрхэм зорилго, үйл ажиллагааны стратеги зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах хүний нөөцийг төлөвлөх, бүрдүүлэх, сонгон шалгаруулах, бэлэн байгаа хүний нөөцийг үнэлэх, ирээдүйн хэрэгцээг тодорхойлох, түүнд хүрэхэд учирч болох эрсдэлийг тооцоолж төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлд суурилсан бүтээлч байдал, чадварлаг суурьшилтай хүний нөөцийг бий болгохын тулд ажилтнуудын мэдлэг, ур чадварыг сайжруулах, манлайллыг дэмжихэд оршино.

2.2 Зорилт:

- ✓ Ажлын байрны хэрэгцээ, шаардлагад нийцсэн чадварлаг, мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэх
- ✓ Хүний нөөцийн тогтвортой хөгжлийг хангаж, чадавхийг бэхжүүлэх
- ✓ Хүний нөөцийн тогтвортой хөгжлийг дэмжих, урамшуулах, эвсэг, чадварлаг хамт олон бүрдүүлэх
- ✓ Хүний нөөцийн тогтвортой хөгжлийг хангахад хамтын ажиллагааг өргөжүүлэх

Гурав. Хамрах хүрээ, хугацаа

3.1 Нэгдсэн Эмнэлгийн нийт эмч ажилчид.

3.2 Хөтөлбөрийг 2023-2025 онд хэрэгжүүлнэ.

Дөрөв. Хэрэгжүүлэх зарчим

4.1 Энэхүү хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд гадаад болон дотоод орчны хүчин зүйлүүд шууд болон шууд бус нөлөөтэй бөгөөд тэдгээрийг нөлөөллөөр нь эрэмблэн тогтмол хянаж, давуу талаа ашиглан сул талаа багасгах, боломжийг ашиглан бэрхшээлийг багасгах зарчмийг баримтлана.

4.2 Монгол Улсын төрөөс ажиллах хүчний нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар баримтлах бодлого хууль тогтоомж, Олон Улсын хөдөлмөрийн байгууллагын конвенци, зөвлөмж, эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжлийн тэргүүлэх чиглэл, бодлоготой уялдуулан зохицуулах

4.3 Сонирхогч бүх талууд, төрийн, төрийн бус байгууллагууд, олон улсын байгууллагуудын оролцоо, үйл ажиллагааны уялдаа холбоог хангаж, түншлэлийг хөгжүүлэх

4.4 Үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, мэдээллийг урсгалыг бүрдүүлэх

4.5 Жендерийн мэдрэмжтэй байх

Тав. Хөтөлбөрийн санхүүжилт:

5.1 Нэгдсэн эмнэлгийн жил бүрийн төсөв

5.2 Олон улсын байгууллагуудын хөрөнгө оруулалт, хандивлагчдын тусалцаа

5.3 Хуулиар зөвшөөрсөн бусад эх үүсвэр

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалт

6.1 Хөтөлбөрийн хэрэгжилтийг мэргэжлийн удирдлага, зохицуулалт мэдээллээр хангах, хөтөлбөрийг төвийн хэмжээнд хэрэгжүүлэх, хэрэгжилтэд явцын хяналт тавих, дүгнэх ажлыг эмнэлгийн удирдлагаар оролцоотойгоор гүйцэтгэнэ.

6.2 Хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагааны зарим хэсгийг гэрээний үндсэн дээр төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж болно.

Долоо. Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

- 7.1 Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээг Үйлдвэрчний эвлэлийн хороо, эмнэлгийн удирдлага.
- 7.2 Хөтөлбөрийг түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний шалгуур үзүүлэлтийг баримтлан жил тутамд дүгнэж, харьцуулсан үнэлгээ өгнө.
- 7.3 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд шаардлагатай бол тухай бүрт нь шинэчлэл хийнэ.

Найм. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө